

“СЭЦ ТҮШИГ АУДИТ” ХХК

АУДИТЫН ТАЙЛАН

“АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР
БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



“СЭЦ ТҮШИГ АУДИТ” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Оюуны-Ундраа группын байр,
3 давхар, 305 тоот
И-мэйл: auditorsets@outlook.com
Утас: 9000-0535

УЛААНБААТАР ХОТ
2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30

SETS TUSHIG AUDIT LLC



“АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК
-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ-д

СЭЦ ТҮШИГ АУДИТ ХХК

АУДИТЫН БОЛОН ЗӨВЛӨХ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Монгол улс, Улаанбаатар хот-49,
Баянзүрх дүүрэг, Эрхэт нөгцөлбөр 75/1
Утас: 99144842, 99913006

И-Мэйл: sets.audit@gmail.com

огноо 2024.04.30 № СТАС2401/23

Аудитын дүгнэлт, зөвлөмж
хүргүүлэх тухай

“АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК болон “СЭЦ ТҮШИГ АУДИТ” ХХК-ийн хооронд байгуулсан “Аудитын үйлчилгээний гэрээ”-г үндэслэн “АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд аудит хийсэн болно. Бидний аудитын ажлын үр дүн болох аудитын дүгнэлтийг танд хүргүүлж байна.

Аудитын дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой тодруулах зүйл байвал бид та бүхнийг хүлээн авахад бэлэн байх болно.

ХҮНДЭТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.ОТГОНБАЯР

SETS TUSHIQ AUDIT LLC

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	1-3
2. Аудитлагдсан санхүүгийн тайлан	4-8
❖ Санхүүгийн байдлын тайлан	4
❖ Орлогын дэлгэрэнгүй тайлан	5-6
❖ Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
❖ Мөнгөн гүйлгээний тайлан	8
3. Зөвлөмж	9



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СЭЦ ТҮШИГ АУДИТ ХХК АУДИТЫН БОЛОН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Монгол улс, Улаанбаатар хот-49,
Баянзүрх дүүрэг, Эрхэт цогцолбор 75/1
Утас: 99144842, 99913006
И-Мэйл: sets.audit@gmail.com

огноо 2024.04.30 № СТАС2401/23

“АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД:

Дүгнэлт

Бид 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн Яамнаас батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

SETS TUSHIG AUDIT LLC

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд боломжтой болгоход зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэхэд явдал юм.

Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа бүх буруу тайлагналыг үргэлж илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлэн, тэдгээр эрсдлүүдэд тохируулахуйц аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлэн, дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоо олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурьдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсч болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Бусад

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.


 “СЭЦ ТҮШИГ АУДИТ” ХХК
 УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС
 8023030452
 2024 оны 04 дүгээр сарын 30

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар
(тогтоогоор)

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31-ний өдөр	2023 оны 12-р сарын 31-ний өдөр
ХӨРӨНГӨ		
<u>Эргэлтийн хөрөнгө</u>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,281,942,352.05	853,354,493.10
Зээл	1,768,331,322.15	2,554,368,514.06
Зээлийн эрсдэлийн сан	(39,940,000.00)	(68,475,000.00)
Бусад авлага	41,728,127.08	241,771,353.20
<i>Эргэлтийн хөрөнгийн дүн</i>	<i>3,052,061,801.28</i>	<i>3,581,019,360.36</i>
<u>Эргэлтийн бус хөрөнгө</u>		
Үндсэн хөрөнгө	4,587,913.30	4,630,320.83
Биет бус хөрөнгө	4,046,144.30	4,046,144.30
<i>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</i>	<i>8,634,057.60</i>	<i>8,676,465.13</i>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,060,695,858.88	3,589,695,825.49
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
<u>Бусад эх үүсвэр</u>		
Бусад өр төлбөр	2,284,199.18	53,599,000.93
<i>Нийт богино хугацаат өр төлбөрийн дүн</i>	<i>2,284,199.18</i>	<i>53,599,000.93</i>
<u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u>		
Урт хугацаат зээл	-	-
<i>Нийт урт хугацаат өр төлбөрийн дүн</i>	<i>-</i>	<i>-</i>
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	2,284,199.18	53,599,000.93
<u>Эзэмшигчдийн өмч</u>		
Энгийн хувьцаа	2,200,000,000.00	2,800,000,000.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	858,411,659.70	736,096,824.56
<i>Эздийн өмчийн дүн</i>	<i>3,058,411,659.70</i>	<i>3,536,096,824.56</i>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,060,695,858.88	3,589,695,825.49

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар
(тогтоогоор)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31-ний өдөр
1	Хүүгийн орлого	653,671,635.55
1.1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	643,999,187.82
1.2	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	9,672,447.73
2	Хүүгийн зардал	-
3	Цэвэр хүүгийн орлого	653,671,635.55
4	Хүүгийн бус орлого	6,504,120.00
5	Хүүгийн бус зардал	78,666,952.66
5.1	Арилжааны болон ханшийн тэгшитгэлийн зардал	-
5.2	Боловсон хүчний холбогдолтой зардал	39,493,000.00
5.2.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	34,500,000.00
5.2.2	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	4,813,000.00
5.2.3	Бусад	180,000.00
5.3	Бусад зардал	39,173,952.66
5.3.1	Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	2,000,000.00
5.3.2	Түрээс	19,217,000.00
5.3.3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	5,237,492.47
5.3.4	Харилцаа, холбооны зардал	3,674,235.00
5.3.5	Шатахуун болон тээврийн зардал	50,000.00
5.3.6	Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	508,800.00
5.3.7	Зохицуулалтын хураамжийн зардал	3,500,000.0
5.3.8	Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	632,500.00

5.3.9	Бичиг хэргийн зардал	619,780.00
5.3.10	Ариун цэврийн зардал	343,620.00
5.3.11	Бусад	3,390,525.19
6	Цэвэр хүүгийн бус орлого /зардлын дүн	(72,162,832.66)
7	Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал	581,508,802.89
8	Болзошгүй эрсдэлийн сан	28,535,000.00
9	Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	552,973,802.89
10	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-
11	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2,759,000.00
12	Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал	550,214,802.89
13	Ердийн бус орлого	-
14	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	550,214,802.89
15	Орлогын татварын зардал	5,529,638.03
16	ЦЭВЭР АШИГ	544,685,164.86

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТНИЙН ТАЙЛАН

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар
(тогтоогоор)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Хувийн өмч	Халаасны хувьцаа	Нэмж тологдсон капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлт	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,200,000,000.00						858,411,659.70	3,058,411,659.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-	-
3	Залруулсан үлдэгдэл	2,200,000,000.00						858,411,659.70	3,058,411,659.70
4	Тайлант үеийн шэвэр ашиг (алдагдал)							544,685,164.86	544,685,164.86
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт	600,000,000.00							600,000,000.00
7	Ногдол ашиг							(667,000,000.00)	(667,000,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,800,000,000.00						736,096,824.56	3,536,096,824.56

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар
(тогтоогоор)

ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31-ний өдөр
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</u>	1,858,194,551.78
Зээлийн хүүгийн орлого	503,147,743.69
Харилцах дансны хүүгийн орлого	-
Гадаад валютын арилжааны орлого	-
Итгэлцлийн үйлчилгээний орлого	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	-
Бусад үйлчилгээний орлого	1,355,046,808.09
<u>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	2,284,023,410.73
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	-
Үндсэн ба нэмэгдэл цалин	27,963,250.00
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	8,780,500.00
Албан томилолт, сургалтын зардал	-
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	19,217,000.00
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	4,233,035.00
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	963,400.00
Татвар, даатгалын төлсөн мөнгө	72,436,420.54
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	-
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	2,700,00.00
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	-
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	2,000,000.00
Зохицуулалтыг үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,500,000.00
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	5,912,400.00
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	2,136,317,405.19
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(425,828,858.95)
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
<u>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого</u>	-
Бусад мөнгөн орлого	-
<u>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	2,759,000.00
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	749,000.00
Бусад	2,010,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(2,759,000.00)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(428,587,858.95)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1,281,942,352.05
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	853,354,493.10

“АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн удирдлагад:

Бид “АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдийн Институтээс зөвшөөрсөн Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу аудит хийж гүйцэтгэсэн тухайгаа энэхүү захидлаар илэрхийлж байна.

Бидний үүрэг хариуцлага бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэх юм. Бидний хийсэн аудит нь санхүүгийн тайлан дахь аудитын горимуудыг төлөвлөх үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэхтэй холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг бөгөөд “АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгогүй юм.

Байгууллагын дотоод хяналтын алдаа дутагдал нь удирдлага болон бусад ажилтнуудыг ажлаа гүйцэтгэх явцад гаргасан алдааг цаг тухайд нь илрүүлж, засварлаж, сэргийлэх боломжгүйгээс үүсдэг.

Бидний зорилго нь байгууллагын дотоод хяналтын систем дэх бүх материаллаг алдааг олж илрүүлэх биш юм. Бид “АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх явцад байгууллагын дотоод хяналтын системээс ямар нэг материаллаг алдаа илрүүлээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитыг хийх явцад хамтран ажилласан танай хамт олонд талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.ОТГОНБАЯР